



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/501

Алтай хот

**Газар эзэмших эрхийн дуудлага
худалдаа зохион байгуулах ажлын
хэсэг томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2021 оны А/477 дугаар захирамжаар зарлагдсан газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаа зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

- Ажлын хэсгийн дарга: Д.Гаадамба -(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга)
- Гишүүдэд: Ц.Эрдэнэбат -(аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
- Ж.Мөнхчимэг -(аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
- Э.Лхагвадулам-(аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн орлогын мэргэжилтэн)
- Б.Бямбадорж -(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга, ерөнхий архитектор)

2.

Нарийн бичгийн дарга: Д. Мөнхтуяа - (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн газрын татвар, төлбөр, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг журмын дагуу 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулж, шалгаруулалтын үр дүнг танилцуулахыг комисс (Д. Гаадамба)-т даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Ж. Мөнхцэцэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О. АМГАЛАНБААТАР